



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар A/133


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/265 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хамгаалалтын сургалт зохион байгуулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /бригадын генерал Г.Сайханбаяр/-т даалгасугай.

САЙД



Н.ЭНХБОЛД

1330100270

Батлан хамгаалахын сайдын 2020 оны

06.. дугаар сарын 16-ны өдрийн

11/33 дугаар тушаалтын хавсралт

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН СУРГАЛТЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журам нь орон нутгийн хамгаалалтын чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж, түүний удирдлага, бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийг хангах сургалтыг төлөвлөх, зохион байгуулж явуулах зарчим, арга, хэлбэрийг тодорхойлоход оршино.

1.2. Засгийн газрын шийдвэрээр орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль, аймаг, нийслэлийн Засаг даргын цугларалтыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

1.3. Сум, дүүргийн Засаг даргын цугларалт, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүн, бусад албан тушаалтан болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр Цэргийн штаб төлөвлөн, зохион байгуулж, явуулна.

1.4. Аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтан орон нутгийн хамгаалалтын сургалтад оролцно.

1.5. Томилгоот иргэн, албан тушаалтан орон нутгийн хамгаалалтын сургалтад хуулиар тогтоосон хугацаа, үечлэлийн дагуу хамрагдах үүрэг хүлээнэ.

1.6. Орон нутгийн хамгаалалтын сургалтыг дараах зарчимд тулгуурлан явуулна. Үүнд:

- 1.6.1. төрийн батлан хамгаалах бодлого, хууль, тогтоомжид нийцсэн байх;
- 1.6.2. суралцагчдын цэрэг-эх оронч ухамсар, идэвхтэй үйл ажиллагаанд тулгуурлах;
- 1.6.3. суралцагчдыг гүйцэтгэх үүрэгт нь заавал сургах;
- 1.6.4. цэргийн сургалтын арга, хэлбэрийг үндэс болгох;
- 1.6.5. сургалтыг болзошгүй ажиллагааны бодит цагийн байдалд ойртуулах.

1.7. Орон нутгийн хамгаалалтын сургалтыг хамрагдах бүрэлдэхүүнээр нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- 1.7.1. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын;
- 1.7.2. орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүн, бусад албан тушаалтны;
- 1.7.3. орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний.

1.8. Сургалтыг дараах хэлбэрээр явуулна. Үүнд:

- 1.8.1. цугларалт;
- 1.8.2. хээрийн дадлага;
- 1.8.3. нэгдсэн сургууль.

## ХОЁР. АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН СУРГАЛТ

2.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарын сургалт нь Засаг дарга наарт онц болон дайны байдлын үед нутаг дэвсгэртээ орон нутгийн хамгаалалтыг бэлтгэж, явуулах талаар мэдлэг олгох, орон нутгийн хамгаалалтыг удирдлагаар хангах, үүссэн цагийн байдалд нийцүүлэн шийдвэр гаргах арга барил, дадлага, чадвар эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарын сургалтыг Засгийн газрын 2018 оны 376 дугаар тогтоолоор батлагдсан “Аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага явуулах журам”-ын дагуу зохион байгуулж, явуулна.

2.3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутгийн хамгаалалтын асуудал хариуцсан нэгж аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарын сургалтыг зохион байгуулсан тайланг тухайн жилийн төгсгөлд батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

## ГУРАВ. ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОМИЛГООТ НЭГЖИЙН УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ

3.1 Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалт нь томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүнд онц болон дайны байдлын үед хуулиар хүлээсэн үүргүүдийг гүйцэтгэх үед томилгоот нэгжийг удирдлагаар хангах, үүссэн цагийн байдалд нийцүүлэн шийдвэр гаргах арга барил, дадлага, чадвар эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

3.2. Энэхүү сургалтыг дөрвөн жил тутам 3-5 хоногийн хугацаатай цугларалт хэлбэрээр зохион байгуулж, явуулна.

3.3. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний цугларалтыг явуулах хугацаа, түүнд оролцох бүрэлдэхүүн, шаардагдах зардлын хэмжээг Цэргийн штабын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

3.4. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтын хөтөлбөрийг аймаг, нийслэлийн Засаг дарга батална.

3.4.1. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтын хөтөлбөрт дараах асуудлыг заавал тусгасан байна.  
Үүнд:

- хууль, эрх зүйн үндэс;
- орон нутгийн хамгаалалтын онолын үндэс;
- цэргийн удирдлагаын үндэс;
- ерөнхий тактик /салаа, рот, батальон/ эсвэл тусгай тактик /тухайн томилгоот нэгжийн томилгоо, үүрэгтэй уялдуулна./;
- томилгоот нэгжийн үүрэг, ажиллагааны арга, тактик;
- галын бэлтгэл;
- амьд гарах арга, ухаан.

3.5. Цугларалтыг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, сургалтын хөтөлбөрийн дагуу Цэргийн штаб зохион байгуулж, явуулна.

3.6. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтад Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

3.7. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний цугларалтыг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын орон нутаг дахь нэгж, тэдгээрийн сургалтын төв, материаллаг баазыг түшиглэн зохион байгуулна.

3.8. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг онол, дадлага хослуулан явуулна. Онолын хичээлийг лекц, үзүүлэн таниулах, харилцан яриа хэлбэрээр, дадлагын хичээлийг бүлгийн дасгал хэлбэрээр тус тус явуулна.

3.9. Сургалтын зохион байгуулалт, явцад батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

3.10. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг явуулсан тухай тайланг тухай бүрт аймаг, нийслэлийн Засаг дарга батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

## ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОМИЛГООТ НЭГЖИЙН СУРГАЛТ

4.1. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалт нь орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж байгуулагдаж, хуулиар хүлээсэн үргийг биелүүлэх үед хүн нэг бурийн биеэр хийж гүйцэтгэвэл зохих дадлага, чадварыг бие бүрэлдэхүүнд эзэмшүүлэх, тасаг, салаа, суманг гар нийлэмжтэй ажиллагаанд сурган жигдрүүлэхэд чиглүүлж дараах зорилтуудыг хангана.

4.1.1. орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бие бүрэлдэхүүнийг томилгоот албан тушаалын үүрэгт нь сурган дадлагажуулах, үүрэг гүйцэтгэх бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хангах, онц болон дайны байдлын үед үүргээ мадаггүй биелүүлэх дадал, ур чадвар олгох, бататгах;

4.1.2. орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдлагыг өөрийн нэгжийг үүрэг гүйцэтгэхэд бэлтгэх, ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад сурган дадлагажуулж, бусад томилгоот нэгж, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан ажиллагаа зохион байгуулах чадвар эзэмшүүлэх;

4.1.3. орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийг онц болон дайны байдлын үед үүргээ биелүүлэх арга, тактик сурган жигдрүүлж, аюулгүй байдлаа хангах, бүх төрлийн хангалтыг бие даан зохион байгуулах, хамтран үүрэг гүйцэтгэх талуудтай харилцан ажиллах арга барилд сургах.

4.2. Энэхүү сургалтыг аймаг, нийслэлд жилд орон нутгийн хамгаалалтын 1-2 томилгоот нэгжтэй хээрийн дадлага хэлбэрээр зохион байгуулж, явуулах бөгөөд сургалтад тухайн томилгоот нэгжид оногдуулан бүртгэгдсэн иргэд хамрагдана.

4.3. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг явуулах хугацаа, түүнд оролцох бүрэлдэхүүн, шаардагдах зардлын хэмжээг Цэргийн штабын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

4.4. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтын хөтөлбөрийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.5. Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, сургалтын хөтөлбөрийг үндэслэн Цэргийн штаб, төрлийн цэргийн командлал, түүний харьяа нэгтгэл, анги,

үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд хамтран хээрийн дадлага, сургуулийн төлөвлөгөөг үүсч болзошгүй цагийн байдалд ойртуулан боловсруулж, аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулна.

4.6. Хээрийн дадлага, сургуулийн төлөвлөгөөнд суралцагчдын хичээллэх цагийг хоногт 10-аас доошгүй цаг байхаар тусгах ба сургуулийн нийт үргэлжлэх хугацаа 7-10 хоног байна.

4.7. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг нэг бүрийн бэлтгэл 1-2 хоног, тасаг, салааны жигдрэлт 3-4 хоног, сумангийн жигдрэлт 3-4 хоног гэсэн үе шаттайгаар төлөвлөн явуулна.

4.8. Сургалтыг Цэргийн штаб гардан зохион байгуулж, явуулах бөгөөд төрлийн цэргийн командлал, түүний харьяа нэгтгэл, анги, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж оролцно.

4.9. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага, сургуулийг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын орон нутаг дахь нэгж, тэдгээрийн сургалтын төв, материаллаг баазыг түшиглэн зохион байгуулна.

4.10. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага, сургуулийг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын тусгай сургууль, дадлагатай хамтатган зохион байгуулж болно. Энэ үед сургууль нэг бодлого, төлөвлөгөөний хүрээнд явагдана.

4.11. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг явуулсан тухай тайланг тухай бүрт аймаг, нийслэлийн Засаг дарга батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

#### ТАВ. ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН НЭГДСЭН СУРГУУЛЬ

5.1. Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль нь онц болон дайны байдлын үед орон нутгийн хамгаалалтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд зохион байгуулах бэлтгэлжилтийн түвшинг тогтоох, удирдлагын үйл ажиллагаа болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүд, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын харилцан ажиллагааг жигдүүлэх, орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтөд дүн шинжилгээ хийх, цаашид боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход чиглэгдэнэ.

5.2. Энэхүү сургалтыг 2 жил тутам аль нэг аймаг, сум, дүүргийг түшиглэн 7-10 хоногийн хугацаатай зохион байгуулж, явуулна.

5.3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль явуулах аймаг, сум, дүүргийг тогтоож, сургууль явуулахаас 2 жилийн өмнө тус аймгийн Засаг даргад мэдэгдэнэ.

5.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль явуулах хугацаа, түүнд татагдан оролцох хүч хэрэгсэл болон шаардагдах зардлын тооцоог боловсруулж, холбогдох саналыг сургууль явуулахаас нэг жилийн өмнө /4 дүгээр сарын 01-ний дотор/ батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.5. Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль явуулах хугацаа, түүнд оролцох хүн, техник хэрэгслийн тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг батлан

хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургууль явуулахаас нэг жилийн өмнө Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

5.6. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуулийн зардлыг тус сургуулийг зохион байгуулж, явуулах аймаг, нийслэлд хуваарилна.

5.7. Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуулийн бодлого, төлөвлөгөөг болзошгүй ажиллагаанд ойртуулсан, өрнөлттэй цагийн байдлын хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрийн цэргийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай хамтран боловсруулж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.8. Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуулийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан бодлого, төлөвлөгөөний дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга удирдан зохион байгуулж, явуулна.

5.9. Нэгдсэн сургуульд батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрийн цэргийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, оролцно.

5.10. Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуульд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулж болно.

5.11. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуулийн төлөвлөлт, бэлтгэл болон зохион байгуулалтын ажлыг Засаг даргын өмнө хариуцна.

5.12. Нэгдсэн сургуулийн хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн удирдлагатай команд штабын сургууль явуулж болно.

5.13. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль явуулсан тухай дэлгэрэнгүй тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг сургууль дууссанаас хойш нэг сарын дотор батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.14. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуулийн дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Засгийн газарт танилцуулна.

## ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн орон нутгийн хамгаалалтын сургалтад шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлнэ.

6.2. Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб тухайн жилийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд орон нутгийн хамгаалалтын сургалтыг тусгаж батлуулна.

6.3. Орон нутгийн хамгаалалтын сургалтад хамрагдсан бүрэлдэхүүний цалинг Засгийн газрын 2019 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэн, цэргийн бэлтгэл үүрэгтнийг орон нутгийн хамгаалалтын болон цэргийн сургалт, дайчилгаатай сургуульд оролцох хугацааны цалин хөлсний дундаж хэмжээг тогтоох, түүнийг олгох журам”-ыг баримтлан олгоно.

6.4. Орон нутгийн хамгаалалтын сургалтад хамрагдахаас зайлсхийсэн иргэн, албан тушаалтанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

#### БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ